



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/100

Улаанбаатар хот

Бүрэн шаталттай зуухны борлуулалтыг
эрчимжүүлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дүүргийн гэр хорооллын хороодод эрчим хүчний хэмнэлттэй, бүрэн шаталттай зуух нэвтрүүлж байгаатай холбогдуулан айл өрхүүдэд сайжруулсан зуухыг сурталчлах, борлуулах нээлттэй өдөрлөг, эрчимжүүлсэн арга хэмжээг 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Өдөрлөгийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, хийгдсэн ажлын дүнг танилцуулахыг Засаг даргын орлогч /Г.Энхболд/-д, ажлыг шуурхай зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажиллахыг Дэд бүтэц, тохижилтын хэлтэс /Э.Батбилэг/-т тус тус даалгасугай.

4. Өдөрлөг зохион байгуулахад шаардагдах 1238000 /Нэг сая хоёр зуун гучин найман мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Тамгын газар /М.Бадрах/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОРОСОО


 Баянгол дүүргийн Засаг даргын 2013 оны
 2-р дугаар сарын 01-ний өдрийн
 А/100 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ, БҮРЭН ШАТАЛТТАЙ ЗУУХ”
 СУРТАЛЧЛАХ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ, БОРЛУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
 АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хөтөлбөр бэлтгэх	2013.03.01	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
2	Сурталчилгааны хөлтэй самбар хэвлүүлэх, хороодод байршуулах	2013.03.01	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
3	Телевиз, мэдээллийн хэрэгслээр урсдаг зар явуулах, зар тавих	2013.03.02- 2013.03.23	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
4	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2013.03.02- 2013.03.23	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
5	Гэр хорооллын Засаг дарга, хэсгийн ахлагч нарт НАЧА-тай хамтран зуух, боловсруулсан түлшний талаар сургалт зохион байгуулах,	2013.03.06	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
6	Иргэдэд бүрэн шаталттай зуух тавьсны ач холбогдлыг таниулсан сурталчилгааны материал бэлтгэх, хороодод тараах /АЗ/	2013.03.01- 2013.03.05	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
7	Бүрэн шаталттай зуухны борлуулалтын цэгийн талаар сурталчилгааны материал бэлдэх, хороодод тараах /АЗ/	2013.03.01- 2013.03.05	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
8	Зуух тавьсан айл өрхтэй хамтарч агаарын бохирдол, зуух тавьсны ач холбогдол, хэрэглээний талаар 3 удаагийн нэвтрүүлэг бэлтгэх	2013.03.04- 2013.03.23	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
9	Телевизийн шторк бэлтгэж, цацах	2013.03.04- 2013.03.23	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба
10	Гэр хорооллын гудамж талбай, хүн ихээр төвлөрдөг газруудад 1 хороонд 3-аас доошгүй явуулын цэг ажиллуулж зуухны сурталчилгаа хийх	2013.03.04- 2013.03.23	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
11	Бүрэн шаталттай, сайжруулсан	2013.03.02-	Дэд бүтэц, тохижилтын

	зуух үйлдвэрлэгчдээс сурталчилгааны материал авч иргэдэд тараах	2013.03.10	хэлтэс
12	Гэр хорооллын хороо бүрт өдөрлөг зохион байгуулах	2013.03.02-2013.03.23	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
13	Хэсгийн ахлагчдын дунд болзолт уралдаан зохион байгуулах	2013.03.01-2013.04.01	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс
14	Ажил эрчимжүүлэх өдөрлөгийн арга хэмжээг дүгнэх	2013.03.25	Дэд бүтэц, тохижилтын хэлтэс